

ОЛОН ТУЙЛТ ДЭЛХИЙН ШИНЭ ДЭГ ЖУРАМ ТӨЛӨВШИХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ БНХАУ-ЫН ҮҮРГИЙГ ШИНЭЭР ҮНЭЛЭХ НЬ

Д.Уламбаяр

*ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын
сургуулийн захирал, доктор, профессор*

Удиртгал

Хятадын гадаад бодлогын судалгаа бол Хятад судлалын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн билээ.

Гадаад, дотоод орчны асар хурдацтай өөрчлөгдөж буй үйл явцтай уялдан шийдвэр гаргах бүх түвшинд мэдлэг, мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээнд тулгуурлахын ач холбогдол хэлбэрэлтгүй өсөн нэмэгдсээр байна. Өнөөгийн даяаршсан, дижиталчлагдаж буй дэлхий ертөнцөд мэдлэг нэн чухал мэдээлэл болж, эргээд мэдээлэл нь нэн чухал мэдлэг болж байгаа явдал бөгөөд энэхүү эргэх орчилд судалгаа, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээний ач холбогдол тасралтгүй өсөн нэмэгдсээр байна.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байх гэдэг нь даяаршлын үед харьцангуй ойлголт бөгөөд тэгэх тусмаа дангаараа бүрэн хангах боломжгүй юм. Тиймээс *үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх үйл явц мөн бөгөөд үүн лүгээ үндэсний аюулгүй байдлын судалгаа, дүн шинжилгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай ажгуу.*

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр хязгааргүй “тэлсэн” явдал юм. *Cyber space* хэмээх хүний оюуны бүтээл болсон тулааны энэ шинэ орон зай хүн төрөлхтний амьдралд язгуур өөрчлөлт гаргаж, цаашид ч олон өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Энэ нь эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, цаг хугацааны алдагдлыг үлэмж бууруулах болов.

Хүн төрөлхтөн дижитал оюун ухаанд суурилсан аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын босгон дээр нэгэнт ирэв. XX зууны сүүлч, XXI зууны эхнээс харилцан хамааралд суурилсан *globalization* эргэлт буцалтгүй болж байгаа тухай ихээхэн ярьж бичиж байсан, харин эдүгээ дэлхий нийтийн хэмжээнд бүх салбарт *digitization* эргэлт буцалтгүй болсон тухай ярьж бичих болов. Үнэхээр бүх салбарт дижитал шилжилт явагдаж байна.

Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа ч багасч байна. Их гүрнүүд гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн хоёр зарчмыг баримталсаар байна.

Эдүгээ *нэгд*, харилцан шалтгаалцал, даяаршил, дижиталчлалын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрх ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов.

Хоёрт, олон улсын хамтын ажиллагааны хамгийн чухал зүйл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд дэлхийн улс орнуудын тогтвортой байдлыг хангах, олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг урт, удаан хугацаанд тогтвортой хадгалах явдал тулгамдсан асуудал болсоор байна.

Гуравт, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дүрмээр тоглодог олон улсын дэг журмыг удаан хугацаанд хадгалах, их гүрнүүдтэй болон хөрш орнуудын хооронд тогтвортой түншлэлийн харилцааг цогцлоох, олон улсын харилцаанд түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлж, дэлхийн хэмжээний даяар асуудлыг шийдвэрлэх, нийт хүн төрөлхтөнд нийтлэг нүүрлэж буй аюул, сорилт, өөрчлөлтүүдийг шийдвэрлэх, даван туулахад оролцоогоо илүү идэвхжүүлэх, Үүнд: Independently, balanced, openness, win-win, inclusive, sustainable, innovative, interaction-learning чухал байна.

Дөрөвт, тэнцвэрийн хүчийг барихаас гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов.

Тавд, төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм. АНУ-ын гадаад бодлогын шинэ параметр, Хятадын эдийн засгийн хөгжлийн удаашрал, Орос-Хятадын иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл, ШХАБ-ын өргөжилт, шинэ өрнөл, Евразийн эдийн засгийн холбооны тэлэлт, Хятад-Америкийн худалдааны дайн, Солонгосын хойгийн тогтворгүй байдал, “Нэг бүс, нэг зам” дэд бүтцийн санаачилга, Brexit, олон улсын терроризм үүний тод илрэл юм.

Улс орнуудын өмнө дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, даяаршиж буй дижитал ертөнцөд дасан зохицохоос гадна, олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад нэгэн адил хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдлаа.

Олон улсын харилцаа бол физикийн entropy төлөв байдал буюу эмх замбараагүй анархи төлөв байдал юм. Олон улсын харилцааны алив юмс үзэгдэл, үйл явц геополитикийн орон зай, цаг хугацаа, таталцлын хүчний гадна оршин байна гэсэн ойлголт байхгүй. Тиймээс өөрчлөлтөд дасан зохицох, хариу барих,

хөрвөх, цохилт буюу ачаалал даах, хүнд нөхцөл байдлаас нэр төртэй гарах явдал чухал болсоор байна.

Тэнцвэрийн хүчийг (Power of Balance) олохоос гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов. Бие биеийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх тухайд Монголын сүсэгтэн олон хийгээд Дээрхийн гэгээн XIV Далай ламын хоорондын харилцааны асуудал ч хамаарагдана. Украины сургамж бол Өрнө дахин, ОХУ-ын хооронд ашиг сонирхлын тэнцвэрийг зөв барих явдал байсан билээ. Энэ бол бидэнд хамаатай чухал сургамж. Эдүгээ олон улсын харилцаа, глобал эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн хүчин зүйлс нь:

- Геополитикийн хүчин зүйлс
- Глобалчлалын хүчин зүйл
- Дижиталчлалын хүчин зүйлс
- Соёл иргэншлийн хүчин зүйлс
- Дэлхийн дулаарал, цаг уурын хүчин зүйлс
- Дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй нийтлэг асуудал эдгээр болно.
- Эцэст нь дэлхий дахиныг хамарсан COVID-19 цар тахал, гэхдээ энэ бол тэс өөр түүх болно.

ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхжиж байгаа нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын дэг тогтолцоо, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхлэв хэмээн судлаачид үзээр байгаа юм. Дээрхтэй холбоотойгоор хүчний шилжих хөдөлгөөн эрчимжиж, дахин хуваарилалт явагдаж байна. Улс хоорондын харилцаа, геополитикийн орчинд шашин болон үндэстэн хоорондын мөргөлдөөн, иргэний дайн, өнгөт хувьсгал, газар нутгийн маргаан, дүрвэгсдийн давалгаа, олон улсын терроризм, экстремизм, сепаратизм, цөмийн болон баллистик пуужингийн заналхийлэл нэмэгдэж, сансрын орон зайд өрсөлдөөн эрчимжиж, эдийн засгийн хориг арга хэмжээ, дангаарших хийгээд протекционизм идэвхжиж, худалдааны шинэ дайн өргөжсөнөөр их гүрнүүдийн хоорондох ашиг сонирхлын зөрчил хурцдах төлөвтэй болж, *тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэж байна.* Их гүрнүүдийн цэргийн зардал тууштай нэмэгдэж байгаа ч энэ нь дайн гарах гол үндэслэл биш, харин аюулгүй байдлаа баталгаажуулж буй хэрэг, их гүрний байр суурь, сүр хүчээ харуулж буй хэрэг, хүчний шилжилт, дахин тэнцвэржүүлэлт, мөн орлогын чухал эх сурвалж болж байна.

Олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явц

Коммунизм нуран унаснаас хойш 1990-ээд онд АНУ дэлхий дээр жолоодогчийн үүрэг гүйцэтгэх тухай үзэл санаа бодлогын шинж чанартай болж байгаад ОХУ, лалын ертөнц ихээхэн эгдүүцэж буй тухай геополитикийн шинжээчид онцлон тэмдэглэж байв. Дээрхийг БНХАУ ганцаараа жанжлах гэсэн

эрмэлзлэл гэж ч хурцаар шүүмжилж байв.

Хүйтэн дайнд ялалт байгуулсандаа эрэмшсэн АНУ, түүний холбоотнууд дэлхий дахинд хүний эрх, эрх чөлөө, ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцааг түгээн дэлгэрүүлэх, сэргээн баталгаажуулах тухай зааж сургаж байв. 2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараа АНУ-ын тэргүүлэх оройлолтой (Pax Americana or American Primacy) олон улсын харилцааны нэг туйлт (unipolarity) дэг тогтолцоо төгсгөл болох үе шат эхэлсэн тухай судлаачид тэмдэглэж эхэлсэн билээ.

XX зууны түүхийн огцом өөрчлөлтүүд, түүнтэй гүн гүнзгий холбоотой улс төрийн сэтгэлгээ болон орчин үеийн олон улсын харилцааны онолын хөгжилтэй уялдан дэлхийн дэг журам хэмээх нэр томъёо олон улсын харилцааны үзэл баримтлалын шинжтэй цогц ойлголт болон гарч ирсэн. Дурдсан ухагдахууны мөн чанар нь эмх замраагүй, хуваагдмал, хүчээр түрээ барьсан хийгээд олон янз, үндэсний явцуу үзэл баримтлалд суурилсан хуучин олон улсын харилцааг хүний эрх, эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан илүү зохистой глобал засаглалаар илбэн тохинуулах замаар өнөөгийн дэлхий ертөнцийг өөрчлөн байгуулах тухай асуудал юм.

Олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцооны үзэл санаа анхлан 1997 оны 4 дүгээр 23-нд Москвад гарын үсэг зурсан “Олон туйлт ертөнц, олон улсын шинэ дэг журмыг цогцлоон байгуулах тухай” Орос-Хятадын Хамтарсан Тунхаглалд¹ тусгалаа олсон юм.

Тунхаглалд: “Талууд түншлэлийн харилцааны үзэл санааг гол болгон олон улсын шинэ дэг журмыг төлөвшүүлэх, олон туйлт ертөнцийн хөгжлийг урагшлуулахын төлөө хүчин чармайлт гаргах болно. “Хүйтэн дайн” төгсөв. Хоёр туйлт тогтолцоо задрав. Олон туйлт ертөнц үүсэн төлөвших нааштай хандлага эрчимтэй хөгжиж, томоохон улсууд, түүний дотор “хүйтэн дайн”-ы үед дайсагналцаж байсан улс хоорондын харилцаа өөрчлөгдсөөр байна... Энх тайван, тогтвортой, шударга бөгөөд үр ашигтай олон улсын улс төр, эдийн засгийн шинэ дэг журмыг байгуулах нь эрин үеийн тулгамдсан шаардлага, түүхийн хөгжлийн зайлшгүй хүчин зүйл мөн... Улс орон бүр өөр өөрийн тодорхой нөхцлөөс хамааран бусад улсын оролцоогүйгээр хөгжлийнхөө замыг бие даан сонгон авах эрхтэй. Нийгмийн байгуулал, үзэл суртал, үнэт зүйлсийн тогтолцооны ялгаа нь улс хооронд хэвийн харилцаа хөгжүүлэхэд саад болох учиргүй. Том жижиг, хүчирхэг буурай, эсвэл баян ядуу гэлтгүй улс орон бүр олон улсын хамтын нийгэмлэгийн эрх тэгш гишүүн мөн. Ямар ч нөхцөлд ноёрхохыг эрмэлзэж хүчээр түрээ барьсан бодлого явуулах, олон улсын хэрэгт дарангуйлан оролцож болохгүй...Талууд аюулгүй байдлын бүх нийтийн ач холбогдол бүхий шинэ үзэл баримтлалыг тогтоохын төлөө байна. Бид “хүйтэн дайн”-ы сэтгэхүйг таягдан хаях ёстой гэж үзэн бүлэглэлийн бодлогыг эсэргүүцэж байна. Олон улсын шинэ дэг журмыг

1 Российско-Китайская совместная декларация о многополярном мире и формировании нового международного порядка. Москва, 23 апреля 1997 года (текст документа с изменениями и дополнениями по состоянию на ноябрь 2007 года)

тогтоон бэхжүүлэхэд НҮБ чухал үүрэгтэй... Олон улсын эрх зүйн зарчмыг чанад сахиж, гуравдагч этгээд рүү үл чиглэсэн шинэ маягийн урт хугацааны харилцааг тогтооно гэдгээ нотолж байна. Энэ нь олон улсын шинэ дэг журам төлөвшихөд чухал практик туршлага болно”¹ гэжээ.

2002 оны 12 дугаар сарын 1-нд Бээжинд гарын үсэг зурсан “ОХУ, БНХАУ-ын Хамтарсан Тунхаглал”-д ““үүрдийн сайн хөрш, сайн найз, сайн түнш байх, үүрд үл дайсагналцах” стратегийн аугаа их үзэл санааг бүрэн дагаж, дэлхий дахины энхийг эрхэмлэгч бүх улс түмний хамт шинэ үеийн сорилтыг угтах шийдвэр төгс байгаагаа нотлов”.²

2003 оны 5 дугаар сарын 26-нд Москвад гарын үсэг зурсан “ОХУ, БНХАУ-ын Хамтарсан Тунхаглал”-д “Аюулгүй байдлын уламжлалт болон уламжлалт бус заналхийллийн хүчин зүйлүүд сүлжилдэн давхцаж, хүчний логик ба нэг талыг баримталсан бодлого нь тэртэй тэргүй тайван бус байгаа ертөнцийг тогтворгүйжүүлэх шинэ хүчин зүйлийг буй болгож байна. Олон улсын терроризм нь даяаршсан занал, нийтлэг гамшиг боллоо. Хятад, Орос хоёр олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад тулгуурласан олон туйлт, шударга, ардчилсан ертөнцийг байгуулах, янз бүрийн улс орны зүй зохистой, бүтээлч ажиллагаа, харилцан зэрэгцэн оршихын төлөө байна”³ гэсэн байна.

Дээрх үзэл санаа ШХАБ, БРИКС-ийн орнуудын дээд түвшний уулзалтын баримт бичгүүдэд тусгалаа олсоор ирэв.

1996 оны 1 дүгээр сарын 9-нд ОХУ-ын Гадаад хэргийн сайдад шинээр томилогдсон Е.М.Примаков атлантизмыг баримталсан А.Козыревын⁴ гадаад бодлогын нэг талыг барьсан чиг шугамыг өөрчилж, олон тулгуурт (многовекторная внешняя политика) гадаад бодлогын шинэ зарчмыг тунхаглаж, ОХУ Хятад, Энэтхэгтэй хамтын ажиллагааг бэхжүүлэхийн чухлыг онцолж, энэ нь өнөөгийн ШХАБ, БРИКС-ийн үндэс суурь болов. Үүнийг л “Примаковын номлол” хэмээн нэрлэж байгаа юм гэж ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров тэмдэглэсэн юм.⁵ Е.М.Примаковыг⁶ Гадаад хэргийн сайдаар ажиллаж байх цаг дор дээрх Тунхаглалд Орос, Хятадын удирдагчид Б.Ельцин, Зян Зэминь нар гарын үсэг зурсан билээ.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2014 оны 10 дугаар сард “Дэлхийн дэг тогтолцоо: Шинэ зүй зохицол уу эсвэл дүрэмгүй тоглоом уу?” сэдвийн дор зохиогдсон “Валдай” олон улсын мэтгэлцээний клубын төгсгөлийн хуралдаанд

1 Там же,

2 Совместная декларация Российской Федерации и Китайской Народной Республики 1 декабря 2002 года. <http://kremlin.ru/supplement/3546>

3 Совместная декларация Российской Федерации и Китайской Народной Республики. 27 мая 2003 года. <http://kremlin.ru/supplement/1669>

4 1990-1996 он хүртэл ОХУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан.

5 Интервью Министра иностранных дел С. В. Лаврова телекомпании ВГТРК в связи с юбилеем Е. М. Примакова, Москва, 28 октября 2014 года

6 1996-1998 онд ОХУ-ын Гадаад хэргийн сайд, 1998-1999 онд ОХУ-ын Засгийн газрын тэргүүн, 1991-1996 онд ОХУ-ын Гадаад тагнуулын албаны захирал, 1989-1990 онд ЗХУК-ын ТХ-ны УТТ-ны орлогч гишүүн, ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Холбооны Зөвлөлийн дарга, 1985-1990 онд ШУА-ийн Дэлхийн эдийн засаг, олон улсын харилцааны хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан, академич.

оролцож үг хэлэхдээ: АНУ-ыг хүйтэн дайны дараа дэлхий дахинд нэгэнт тогтсон дэг журмыг эвдсэнд буруутгаж, дэлхий ертөнцийг зохион байгуулах шинэ тогтолцоог буй болгохгүй бол бүхэлдээ анархи, эмх замбараагүй байдалд орж болзошгүйг сануулж, Орос, АНУ хоёр болсон үйл явдлыг хамтран дүгнэж, Хятад зэрэг томоохон эдийн засагтай бусад орнуудтай хамтран олон туйлт ертөнцийн үзэл баримтлалын дагуу дэлхийг удирдах нэгдсэн шинэ дэг тогтолцоог цоглоон бүтээхийг уриалсан юм.¹

БНХАУ-ын шинэчлэлийн 40 жилийн туршлага нь Хятад онцлогтой социализмын асар их нөөц боломж, түүний давуу талыг нээн харуулж, энэ нь олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад үлэмж эерэг нөлөө үзүүлсээр байна гэж үздэг. 2017 оны 10 дугаар сард хуралдсан ХКН-ын XIX их хурал БНХАУ “хоёр 100 жилийн зорилт”-ыг хэрэгжүүлснээр баян чинээлэг, хүчирхэг, ардчилсан, соёл иргэншсэн, эв зохицолт, үзэсгэлэнт бүхий төгс шинэчлэгдсэн Хятад онцлогтой социалист аугаа их гүрэн улс болно гэдгийг зарлав. Үзэсгэлэнт Хятад улсыг цогцлоох гэдэг шинэ томьёолол нь хятад мөрөөдөл бөгөөд байгаль орчинтойгоо дасан зохицож ногоон хөгжлийг хэрэгжүүлнэ гэсэн үг ажээ.

Хятадын олон үндэстний аугаа их сэргэн мандалтыг хэрэгжүүлэх нь ойрх үеийн түүхээс нааших Хятадын ард түмний хамгийн аугаа их мөрөөдөл бөгөөд үүнийг “Хятад мөрөөдөл” гэж нэрлэж байна. Үндсэн агуулга нь улс орон баян хүчирхэг болж, бүх үндэстэн цэцэглэн хөгжиж, ард түмэн аз жаргалтай байх явдал.²

Хятадын удирдагчийн дэвшүүлсэн “хамтран ажиллах, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх” зарчим нь олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үе шатанд хамтын ажиллагааны хамгийн боломжит хувилбар ажээ.

Хятадын удирдагч Ши Жиньпин 2013 оны 4 дүгээр сард Боаогийн Азийн форумд илтгэл тавихдаа: “Хятад улс бол дэлхийн хамгийн том хөгжиж буй орон хэвээр байна”³ хэмээн дүгнэсэн байдаг. БНХАУ өөрийгөө их гүрэн гэдгээс зайлсхийдэг. 1999 оны 6 дугаар сард ХБНГУ-ын Вестфалийн Кёльн хотод болсон Их наймын дээд түвшний уулзалтад Германы канцлер Герхард Шрёдер Хятадыг Их наймд нэгдэхийг урьсан байдаг.⁴⁽⁵⁾ Өмнөх 1997 оны 6 дугаар сард АНУ-ын

1 В.Путин принял участие в итоговой пленарной сессии XI заседания Международного дискуссионного клуба «Валдай». Тема заседания-«Мировой порядок: новые правила или игра без правил?». 24 октября 2014 года. Сочи.: РФ

2 Ши Жиньпин. Москвад ОХУ-ын ГЯЯ-ны ОУХИС дээр хэлсэн үг. “Цаг үеийн урагшлах чиг урсгалтай хөл нийлүүлэн, дэлхийн энхтайван, хөгжил цэцэглэлд тус дөхөм үзүүлцгээе” 2013.03.23- Ши Жиньпин: Төр улсыг засах тухай I. Admon Printing, Publishing & more.: 2019, 353 дахь тал

3 Ши Жиньпин. “Ази тив болон дэлхийн сайн сайхан ирээдүйг хамтдаа бүтээн байгуулцгаая” 2013.04.07- Ши Жиньпин: Төр улсыг засах тухай I. Admon Printing, Publishing & more.: 2019, 429 дэх тал

4 G7/8 Summits 1999 Köln Summit. Chancellor: Summit Was “Extraordinary Success” — “Far-Reaching Decisions for the World Economy”-Gerhard Schroeder, German Chancellor Press Release, Köln, Germany, June 21, 1999

5 1999 оны 5 дугаар сарын эхээр НАТО-гийн агаарын хүчин Сербийн нийслэл Белгард хотыг бөмбөгдөхөд Хятадын ЭСЯ ноцтой өртсөн учраас Хятадын удирдагч Зян Зэминь оролцохоос татгалзсан юм.

Денверт зохиогдсон Их долоогийн уулзалтад Ерөнхийлөгч Б.Клинтон ОХУ-ыг урьж оролцуулснаар Их наймын бүлэг байгуулагдсан байв. Гэхдээ БНХАУ өөрийгөө их гүрэн биш гэж үздэг, чингэхдээ олон улсын харилцаанд аль нэг, эсвэл хэсэг бүлэг их гүрэн жанжлахын эсрэг байр суурьтай байдаг.¹

ШХАБ-ыг олон туйлт дэлхийн шинэ дэг журмын тулгын багана гэж үзэх агаад БНХАУ тус байгууллагыг үндэслэгчдийн нэг юм. 1996 оны 4 дүгээр сард “Шанхайн тав” хэмээх бүс нутгийн хамтын ажиллагааны бүтэц үндэс сууриа тавьж, 2001 оны 6 дугаар сард БНХАУ-ын Шанхай хотноо зохиогдсон дээд түвшний уулзалтаар ШХАБ-ыг үүсгэн байгуулах тухай Тунхаглал болон Шанхайн конвенцид гарын үсэг зуржээ. Тунхаглалд: “сайн хөршийн харилцаа, оролцогч улс хоорондын харилцан итгэлцэл, найрамдал, бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг бэхжүүлэх, хамтран хөгжих явдлыг дэмжин гүнгийрүүлэхэд “Шанхайн тав”-ын таван жилийн турш орших хугацаандаа гүйцэтгэсэн эерэг үүргийг өндрөөр үнэлэн, “Шанхайн тав”-ыг байгуулж хөгжүүлэх, “хүйтэн дайн” эцэс болсны дараах нөхцөл байдалд хүн төрөлхтний хэрэгцээ эрмэлзэл, энх тайван болон хөгжил рүү тэмүүлсэн түүхэн хандлагад зохицох, өөр өөр иргэншил болон олон янзын соёлын уламжлал тээгч улс орнуудын хооронд харилцан хүндэтгэл, харилцан итгэлцлээр дамжин сайн хөршийн харилцаа, нэгдэл болон хамтын ажиллагааны үлэмж нөөц чадавхийг дэлгэрүүлнэ гэдэгт санаа нэг байж...бүс нутаг болон дэлхий нийтийн энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг дэмжих үйлст чухал хувь нэмэр оруулсан, орчин үеийн дипломат болон бүс нутгийн хамтын ажиллагааны практикийг нэн баяжуулсан, олон улсын хамтын нийгэмлэгт өргөн, эерэг нөлөө үзүүлснийг онцлон тэмдэглэж, төрийн тэргүүн нар XXI зуунд улс төрийн олон туйлт, эдийн засгийн болон мэдээллийн даяаршлын үйл явцын эрчимтэй хөгжлийн нөхцөлд “Шанхайн тав”-ын механизмыг хамтын ажиллагааны илүү өндөр түвшинд шилжүүлэх нь нээгдэж буй боломжийг илүү бүтээмжтэй хамтран ашиглах, шинэ сорилт, аюулын эсрэг зогсоход хувь нэмэр оруулна гэдэгт бат итгэн дараах зүйлийг ёслол төгөлдөр тунхаглаж байна”² гэжээ.

2002 оны 12 дугаар сарын 1-нд Бээжинд гарын үсэг зурсан “ОХУ, БНХАУ-ын Хамтарсан Тунхаглал”-д: “ШХАБ нь өнөөгийн бүс нутгийн энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг хамгаалах чухал хүчин зүйл болсон төдийгүй, ирээдүйн олон туйлт тогтолцооны тулгуур баганын нэг болно” гэж онцолсон юм.³

2020 оны 9 дүгээр сард Москва хотноо зохиогдсон ШХАБ-ын Гадаад харилцааны сайд нарын уулзалтад үг хэлэхдээ: Энэ жил НҮБ үүсгэн байгуулагдсаны 75 жилийн ой тохиож байгаа бөгөөд энэхүү олон улсын байгууллагад үндэслэн дэлхийн дэг журмыг сахиулах нь бүх улс орны нэгдмэл

1 Ши Жиньпин. “Энх тайванч хөгжлийн замаар замнах нь хятадын ард түмний хөгжлийн зорилгоо хэрэгжүүлэх өөртөө итгэх итгэл, ухамсар мөн” 2014.03.28-Ши Жиньпин: Төр улсыг засах тухай I. Admon Printing, Publishing & more.: 2019, 344 дэх тал

2 Декларация о создании Шанхайской организации сотрудничеств. 15 июня 2001, Шанхай, КНР <http://rus.sectsco.org/>

3 Совместная декларация Российской Федерации и Китайской Народной Республики 1 декабря 2002 года. <http://kremlin.ru/supplement/3546>

байр суурь юм... “Харамсалтай нь дэлхийн том гүрэн болсон АНУ өөрсдийгөө хамгийн чухал гэж үзэх “*America First*” бодлогоо тууштай баримталсаар байна. Тэд дангаарших чиг шугамыг баримталж, гэрээнүүдээсээ гарч, зүйл заалтуудыг нь зөрчиж, олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаасаа татгалзаад зогсохгүй бусад улс орны үндэсний ашиг сонирхолд хохирол учруулах янз бүрийн үндэслэлүүдийг бий болгох арга замыг эрэлхийлж байна. АНУ дэлхийн нийтийн дэг журмыг хамгийн гол эвдэгч нь болжээ” хэмээн Ван И цохон тэмдэглэв. ШХАБ олон талт зарчмыг дэмжиж, НҮБ-д суурилсан олон улсын эрх зүйн тогтолцоогоо хамгаалах ёстой гэдгийг Ван И тэрбээр цохон дурджээ. Олон улсын харилцааг ардчилах нэрийн дор нэг талыг барьсан “хүчээр түрээ барих ширэнгийн хуульд (the law of the jungle) дэлхий дахиныг татан оруулах харгис хүчний бодлогыг ШХАБ тууштай сөрөн зогсох ёстой”¹ хэмээн тэрбээр хэлсэн байна.

БРИКС (Brazil, Russia, India, China and South Africa-BRICS) нь аанай л олон туйл дэлхийн шинэ дэг журмыг бүрдүүлж буй бүтцийн нэг юм.²

1 Wang Yi Attends the Meeting of the SCO Council of Foreign Ministers.2020/09/10

https://www.fmprc.gov.cn/mfa_eng/zxxx_662805/t1814554.shtml#:~:text=On%20September

2 Америкийн үндэстэн дамнасан олон улсын хөрөнгө оруулалтын “*Goldman Sachs Group, Inc.*” банкны Глобал эдийн засгийн судалгааны тэргүүн, доктор Жим О’Нейллийн «*Building Better Global Economic BRICs*» нэртэй судалгааны өгүүлэл 2001 оны 11 дүгээр сарын 31-ний “*Global economics paper №66*”-т анх удаа нийтлэгджээ. Тэрбээр энэхүү өгүүлэлдээ хөгжингүй эдийн засагтай Их долоогийн бүлгийн орнуудаас гадна дэлхийн эдийн засагт Бразил, ОХУ, Энэтхэг, Хятад эрчимтэй хөгжиж буйг онцлон тэмдэглээд тэдгээр дөрвөн орны нэрийг хураангуйлан БРИК гэж нэрлэсэн юм. БРИК-ийн дөрвөн орны Гадаад хэргийн сайд нарын анхны уулзалт 2006 оны 9 дүгээр сард Нью-Йоркт НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 61 дүгээр чуулганы үеэр болж, удалгүй 2008 оны 7 дугаар сард Японы Хоккайдо аралд Их наймын бүлгийн (G8) 34 дэх удаагийн дээд түвшний уулзалтын хүрээнд зохиогдсон арга хэмжээний үеэр тус арал дээр ОХУ-ын Ерөнхийлөгч Дмитрий Медведев, БНХАУ-ын дарга Ху Жиньтао, Энэтхэгийн Ерөнхий сайд Манмохан Сингх, Бразилын Ерөнхийлөгч Луис Инасилу Лула да Силва нар *briefly* уулзаж БРИКС-ийн дээд түвшний анхны уулзалтыг 2009 оны 6 дугаар сард ОХУ-д зохион байгуулахаар тохиролцсон юм. Тийнхүү БРИК-ийн анхны дээд түвшний уулзалт 2009 оны 6 дугаар сард ОХУ-ын Екатеринбург хотноо зохион байгуулагджээ. 2010 оны 8 дугаар сард БРИК-т Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс нэгдэх хүсэлтийг авч хэлэлцээд 2010 оны 12 дугаар сарын 24-нд тус улсыг БРИК-т нэгдсэнийг албан ёсоор зарласан юм. 2011 оны 4 дүгээр сард Хятадын Санья хотноо болсон БРИК-ийн дээд түвшний уулзалтад Өмнөд Африкийн Ерөнхийлөгч Жейкоб Г.Зума анх удаа уригдан оролцсоноор БРИКС буй болов. БРИКС-ийн таван орон нь Их 20-ийн бүлэгт багтдаг бөгөөд 2019 оны байдлаар дурдсан таван орны ДНБ-ийн нийлбэр 19.6 их наяд ам.доллар буюу дэлхийн ДНБ-ий 23.2 хувь, 32.7 сая км² нутаг дэвсгэрт 3.2 тэрбум хүн ам оршин амьдарч, 4.46 их наяд ам.долларын гадаад валютын нөөцөөр хэмжигдэж байв. 2013 оны 3 дугаар сард Өмнөд Африкийн Дурбан хотноо зохион байгуулагдсан БРИКС-ийн 5 дахь удаагийн дээд түвшний уулзалтаар 50 тэрбум ам. долларын дүрмийн сан бүхий Хөгжлийн банк байгуулах асуудлаар санал нэгдэж, 2013 оны 9 дүгээр сард Санкт-Петербургт зохиогдсон Их 20-ийн дээд түвшний уулзалтын үеэр БРИКС-ийн орнуудын удирдагчид Хөгжлийн банк байгуулах хэлэлцээрт гарын үсэг зуржээ. 2014 оны 7 дугаар сард Бразилийн Форталеза хотод БРИКС-ийн төр, засгийн тэргүүн нарын уулзалт зохион байгуулагдав. Энэ уулзалт ОХУ Крымын хойгийг өөртөө хүч түрэн нэгтгэсний дараа, Энэтхэгт шинэ Засгийн газар байгуулагдаж Ерөнхий сайдаар сөрөг хүчний тэргүүн Нарендра Моди сонгогдож, арван жил үргэлжилсэн Орос, Хятадын хийн хэлэлцээр эцэслэн байгуулагдаж, Бразилын шигшээ баг Дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд ялагдсаны дараа болсноороо онцлог байв. Уулзалтын үеэр БРИКС-ийн Хөгжлийн шинэ банк байгуулах Төгсгөлийн

Шинжээчид Бразил, ӨАБНУ-ын эдийн засаг төсөв болон төлбөрийн тэнцлийн алдагдал, гадаад өр, зээлийн хүндрэлтэй тулгарч, ОХУ Өрнөдийн эдийн засгийн хоригт орж, Хятадын эдийн засгийн өсөлт удааширч эхэлснээр БРИКС-ийн үүрэг, жин нөлөө бүдгэрч байна гэж үзэх болсон билээ.

2017 оны 9 дүгээр сард Хятадын Сямэнь хотноо зохиогдсон БРИКС-ийн дээд түвшний уулзалт үүнийг үгүйсгэхийг хичээсэн. Гэвч 2018 оны сүүлчийн улиралд Бразилийн ерөнхийлөгчөөр баруун төвийн үзэлт Жайр Болсонару ялсан нь БРИКС-ийн байр суурьт зохих сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзэж байсан юм.

Олон туйлт дэлхийн шинэ дэг журмыг бүрдүүлж буй нэг чухал бүтэц болох **ЕАЭЗХ** нь бүс нутагт өрнөж буй нэгдсэн зах зээл, эдийн засгийн интеграцийг хэрэгжүүлж байна. 2015 оны 5 дугаар сард Москвад ЕАЭЗХ, Хятадын Торгоны замын Эдийн засгийн Бүслүүр хоорондын бүтээн байгуулалт дахь хамтын ажиллагааны хамтарсан Тунхаглалд гарын үсэг зурсан юм.¹ БНХАУ, ЕАЭЗХ-ын хооронд чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээний эхний үе шат 2016 оны 10 дугаар сард Москва хотод эхлэв.

2018 оны 5 дугаар сард Нур-Султан хотноо зохион байгуулагдсан эдийн засгийн форумын үеэр ЕАЭЗХ, БНХАУ-ын хооронд худалдаа-эдийн засгийн талаар хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурж², хэлэлцээр 2019 оны 10 дугаар сард хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ.³

Хоёр хөрш иж бүрэн стратегийн түншлэлийн зүгт

ОХУ, БНХАУ тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон 2003 онд ОХУ-тай *“Сайн хөршийн уламжлалт түншлэл”*, 2009 онд *“Стратегийн түншлэл”*, 2019 онд *“Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэл”*, 2003 онд БНХАУ-тай *“Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл”*, 2011 онд *“Стратегийн түншлэл”*, 2014 *“Иж бүрэн стратегийн түншлэл”*-ийн харилцааны эрх зүйн үндсийг тавив.

2018 онд Хятадтай хийсэн гадаад худалдаанд Монгол Улс 4.5 тэрбум

хэлэлцээрт гарын үсэг зурав. Шанхайд байрлах банкны дүрмын санг өсгөж, 100 тэрбум ам.доллар байхаар тохиролцов. Эхний ээлжинд 10 тэрбум ам. доллараар санг бүрдүүлж, 7 жилийн хугацаанд 2 тэрбум ам долларыг гишүүн улс бүр жил бүр гаргах бөгөөд нийтдээ Хятад 41 тэрбумыг, Бразил, ОХУ, Энэтхэг тус бүр 18 тэрбумыг, ӨАБНУ 5 тэрбумыг гаргахаар болжээ. Банк 2016 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд банкны анхны ерөнхийлөгчийг Энэтхэгээс томилсон юм.

1 Joint Statement on Cooperation on the Construction of Joint Eurasian Economic Union and the Silk Road Projects. Moscow.: May 8, 2015

2 ЕАЭС и Китай подписали соглашение о торгово-экономическом сотрудничестве. 17 мая, 2018, ТАСС

3 Соглашение о торгово-экономическом сотрудничестве между ЕАЭС и КНР не предусматривает отмену и снижение пошлин https://ru.sputniknews.kz/press_center/20190916/11536561/eaes-zony-svobodnoy-torgovli-china.html

ам.долларын ашигтай гарсан байхад Монгол Улс Хятадаас хараат байна гэж тайлбарлаж буй нь ихээхэн учир дутагдалтай болно.¹

2013 оны 10 дугаар сарын 25-нд Бээжинд хоёр улсын Ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан *“Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны хөтөлбөр”* нь хамтын ажиллагаагаа тодорхой салбаруудаар хэрэгжүүлэх *Замын зураглал* болж байгаа юм.²

2014 оны 8 дугаар сард Монгол, Хятадын төрийн тэргүүн нар Улаанбаатар хотод хоёр орны харилцааг *Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүрсэн хэмээн дүгнэж*, уг харилцааг хөгжүүлэх Тунхаглалд гарын үсэг зурсан нь³ чухал ач холбогдолтой үйл явдал болов.

Талууд Монгол, Хятадын харилцааны өндөр түвшинд хөгжиж буй таатай үндэс суурь болон бодит шаардлагад үндэслэн, хоёр улс, хоёр ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн стратегийн түншлэлийн харилцааг улам бүр гүнзгийрүүлэх хамтын хүсэл эрмэлзлэлийн дагуу мөнхөд итгэлтэй, хариуцлагатай сайн хөрш, сайн түнш, сайн анд байхын тулд Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны түвшинг дээшлүүлэн Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоохоор санал нэгтгэйгээр тохиролцов.

Хоёр улсын удирдагч нар янз бүрийн шугамаар уулзалдаж, стратегийн зохицуулалтыг эрчимжүүлж, улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлнэ гэж үзсэн юм.

Түншлэлийн харилцааны мөн чанар, хамрах хүрээ

Түншлэлийн харилцаа нь хамтын ажиллагааны ямар нэг хатуу тогтсон үзэл сурталд тулгуурладаггүй, харин улс орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхтэй, харилцан ашигтай, хөгжлийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг тэргүүн зэрэгт тавих, улс бүрийн ялгаатай соёл иргэншил, амьдралын ёс жаягийг ойлгон хүндэтгэх, зөвшлийн үндсэн дээр шийдвэр гаргана гэж үйл ажиллагаандаа баримтлах зарчмаа тодорхойлж байна. Тэгэхлээр түншлэл нь “иж бүрэн” байж болно, “стратегийн” байж болно, “олон талтай”, эсвэл “өргөн хүрээтэй” байж болно, мөн “оюун санааны” түншлэл байж болно. Өөрөөр хэлбэл, хоёр тал харилцаа, хамтын ажиллагааны онцлог, ашиг сонирхлоос хамааран түншлэлийн харилцаагаа янз бүрээр тодотгож, томъёолон гаргаж ирж байгаа ч утга агуулга нь хоорондоо адил төстэй юмуу, ижил байдаг. Зарим орон “стратегийн” гэдэг үгнээс зайлсхийдэг.

1 Үндэсний статистикийн хороо. 2019 https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1400_001V1&GH1_select_all=0&GH1SingleSelect=_4

2 Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны Хөтөлбөр. УБ.: 2013.10.25

3 Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан Тунхаглал. УБ.: 2014.08.21

“Стратегийн түншлэл”-д уламжлалт болон уламжлалт бус аюул, түүний аюулгүй байдлын асуудал, энх тайвныг сахин хангах, олон улсын терроризмын эсрэг тэмцэх, чөлөөт худалдааны хэлэлцээр гол төлөв тусгагдсан байдгаас гадна гол нь энэ харилцаа урт хугацаанд тогтвортой, бүх талыг хамран үргэлжилнэ гэсэн санаа хамт явж байдаг байна. Харин энд “холбоотны буюу эвслийн” эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих буюу харгалзах, “ах дүүгийн” харилцааны ах нь сургах, дүү нь сонсох агуулга суурилдаггүй бөгөөд үүгээрээ түншлэгч талуудын тэгш эрх хангагдаж буй гэж үзэж болно. Мөн өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь хамтын хариуцлага хүлээдэг. Тэгэхлээр түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрсаг харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн юм.

Зарим улс орон стратегийн түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч орчин үеийн олон улсын харилцааны шинэ дэг тогтолцоо бүрэлдэн тогтох үйл явц өрнөж байгаа өнөө үед түншлэл нь гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн шинж байх ёсгүй. Даяаршлын одоо үед түншлэлийн эдийн засгийн утга, агуулга нь улам өргөжин тэлж байна. Нөгөө талд Монгол Улсын орон зайн байршил, байгалийн баялаг хоёр геополитикийн гол хүчин зүйл болов.

БНХАУ-ын хөрш орнуудтай тогтоосон түншлэлийн харилцааг эрэмбэлвэл *нэгд*, ОХУ-тай “Иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл (Russia-China Comprehensive Strategic Interaction Partnership)”, Пакистантай “Мөнхийн стратегийн хамтын ажиллагааны түншлэл (Sino-Pakistan Eternal Strategic Partnership), *хоёрт*, Камбож, Лаос, Мьянмар, Тайланд, Вьетнамтай “Comprehensive Strategic Cooperation Partnership”, БНСУ, Энэтхэг, Афганистантай “Strategic Cooperation Partnership”, *гуравт*, Монгол Улс, Казахстан, Малайз, Индонезитай “Comprehensive Strategic Partnership”, Киргизстан, Тажикстан, Туркменстан, Узбекистантай “Strategic Partnership”, *дөрөвт*, Бангладеш, Балбатай “Comprehensive Cooperation Partnership”, Бруней, Филиппинтэй “Strategic Cooperation Relationship” гэсэн эрх зүйн дараалалтай ажээ.¹ Эндээс харахад Монгол Улс БНХАУ-ын *гадаад бодлогод гуравт эрэмбэлэгдэж* байна.

Firstly	
Sino-Russia	Comprehensive Strategic Interaction Partnership
Sino-Pakistan	Eternal Strategic Partnership
Secondly	
Cambodia, Lao, Myanmar, Thailand and Vietnam	Comprehensive Strategic Cooperation Partnership
Republic of Korea, India, and Afghanistan	Strategic Cooperation Partnership

1 Б.Шүрэнтана. “БНХАУ-ын Хөрш орнуудын бодлого дахь Хятад-Монголын харилцаа, түүний онцлог агуулга” Лиү Бөвэн, Фан Чанпин нарын БНХАУ-ын түншлэлийн ангилал. -Замбуулан. сэтгүүл. Орчин үеийн Хятад судлалын төв, АСЕАН, Хятад судлалын төв. 2019, №1, 86-97 дахь тал

<i>Thirdly</i>	
Mongolia, Kazakhstan, Malaysia and Indonesia	Comprehensive Strategic Partnership
Kyrgyzstan, Tajikistan, Turkmenistan and Uzbekistan	Strategic Partnership
<i>Fourthly</i>	
Bangladesh and Nepal	Comprehensive Cooperation Partnership
Brunei and Philippines	Strategic Cooperation Relationship

Гурван хөршийн саммитын шинэ парадигм

Монгол Улсын гадаад бодлогод гарсан шинэ парадигм бол гурван хөршийн дээд түвшний уулзалтын эрх зүйн үндэс тавигдаж, байнгын механизм буй болсон явдал юм. Энэ нь олон туйлт дэлхий шинэ дэг журам төлөвших үйл явц идэвхжиж буй үед Монгол Улсад чухал ач холбогдолтой байв.

Тийнхүү Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын анхны гурван талт дээд түвшний уулзалт 2014 оны 9 дүгээр сард Тажикстаны нийслэл Душанбе хотноо амжилттай зохион байгуулагдав. Уулзалтаар Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нар уулзалтын агуулга, зарчмыг хэлэлцэж байх асуудлын тухай Монгол Улсын санаачилгын талаар тийнхүү хэлэлцэж, тодорхой ойлголцол, тохиролцоонд хүрсэн юм.

2015 оны 7 дугаар сард ОХУ-ын Башкирын нийслэл Уфа, 2016 оны 6 дугаар сард Ташкент хотод зохиогдсон гурван хөршийн гурав дахь удаагийн дээд түвшний уулзалтаар Орос, Монгол, Хятадыг дамнасан эдийн засгийн коридор байгуулах асуудлаар санал нэгдэж, 32 төсөл дээр тохиролцсон билээ. 2018 оны 8 дугаар сард Москвад чуулсан шинжээчдийн уулзалтаар батлагдсан 32 төслөөс эхний ээлжинд тэргүүлэх гурван чиглэл болох эрчим хүчний сүлжээ, төмөр замын коридор, автозамын коридор дээр төвлөрч, Монгол Улсын ГХЯ-нд гурван талын Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулахаар болсон юм.

Гурван хөршийн Чиндаогийн дээд уулзалт шинэ үе шат болов. 2018 оны 9 дүгээр сард болсон Дорны эдийн засгийн форумын үеэр урагш алхсан нэг асуудал нь Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор бий болгох ажлыг хамтран урагшлуулах байнгын механизмтай болох тухайд гурван улсын холбогдох яамд хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан явдал болно.

2019 оны 6 дугаар сард Киргизийн нийслэл Бишкек хотноо ШХАБ-ын дээд уулзалтын хүрээнд ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын гурван талт дээд түвшний уулзалт зохион байгуулагдав.

ОХУ-аас БНХАУ-д нийлүүлэх хий дамжуулах Сибирийн хүч, Алтай уулын шугамын чадавх ирээдүйн өсөн нэмэгдэж буй Хятадын эрэлт хэрэгцээг бүрэн

хангаж чадахгүй нь тодорхой болж, 1100 км дөт Монголын магистраль чухалд тооцогдож, Оросоос Монголын нутгаар дамжуулан Хятадад хий нийлүүлэх ажил эрчимтэй хөдөлж эхлэв. Чиндао хотноо санал болгосон Ерөнхийлөгч Х.Баттулгын саналыг Оросын тал дэмжиж, Владивостокт Ши Жиньпин судлаж үзэхээ амлаж, 2019 оны 12 дугаар сард Ерөнхий сайд У.Хүрэсүхийн айлчлалаар эрх зүйн үндсийг багтай тавив.

Монгол Улсын хөгжлийн нэг гол загвар бол төмөр зам, авто зам, эрчим хүчний сүлжээ, хий дамжуулах идэвхтэй транзит, газрын гүүр улс болох явдал юм.

Үнэлгээ:

Нэгд, ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхжиж байгаа нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын дэг тогтолцоо, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхлэв хэмээн өрнөдийн судлаачид үзсээр байгаа юм. Дээрхтэй холбоотойгоор хүчний шинэ шилжилт хөдөлгөөн эрчимжиж, дахин хуваарилалт явагдаж байна.

Хоёрт, Улс хоорондын харилцаа, геополитикийн орчинд шашин болон үндэстэн хоорондын мөргөлдөөн, иргэний дайн, өнгөт хувьсгал, газар нутгийн маргаан, дүрвэгсдийн давалгаа, олон улсын терроризм, экстремизм, сепаратизм, цөмийн болон баллистик пуужингийн заналхийлэл нэмэгдэж, сансрын орон зайд өрсөлдөөн эрчимжиж, эдийн засгийн хориг арга хэмжээ, дангаарших, протекционист бодлого идэвхжиж, худалдааны шинэ дайн өргөжсөнөөр их гүрнүүдийн хоорондох ашиг сонирхлын зөрчил хурцдах төлөвтэй болж, ***тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэх болов.***

Гуравт, Даяаршил, дижиталчлалын үед хамгийн хүчирхэг батлан хамгаалах чадавхтай, хамгийн хүчирхэг эдийн засагтай улс гүрэн ч өөрийн аюулгүй байдал, хөгжил дэвшлийг дангаараа хангаж хөтлөн авч явах бололцоогүй болов. Энэхүү дүгнэлт АНУ, БНХАУ, ОХУ-ын аль алинд нь хамаарна.

Дөрөвт, БНХАУ-ын шинэчлэлийн 40 жилийн туршлага нь Хятад онцлогтой социализмын асар их нөөц боломж, түүний давуу талыг нээн харуулж, энэ нь олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад эерэг нөлөө үзүүлсээр байна. “Хоёр 100 жил”-ийн тэмцлийн зорилтыг хэрэгжүүлснээр 2021 он гэхэд дундаж чинээлэг нийгмийг иж бүрэн байгуулах, шинэ Хятад улс байгуулагдсаны 100 жилийн ой гэхэд орчин үеийн баян, хүчирхэг, ардчилсан ёст, соёл иргэншилт, эв зохицолт социалист аугаа их гүрнийг цогцлоон байгуулах ажээ. Хятадын онцлогтой социализмын туршлага бол байнга төвийг сахисан Швейцарь лугаа дахин давтагдашгүй юм.

Тавд, АНУ-ын олон улсын нэрт тоймч Тед Коппел БНХАУ-ыг *The People's Republic of Capitalism* буюу Ардын Бүгд Найрамдах Капитализм гэж нэрлээд өнөөгийн Хятадад ХКН тэрбум илүү хүн амд бүрэн хүрч ажиллах боломжгүй, тиймийн учир үлдсэн хэсгийг капитализм авч явах учиртай гэжээ. Үүнийг л

Хятадын *paradox* хэмээх ажгуу.

Зургаад, Өрнөдийн эдийн засгийн хоригийн дараа ОХУ, БНХАУ-ын улс төр-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа огцом эрчимжсэн нь Монгол Улсын геополитик, гео-эдийн ач холбогдлыг өсгөж байгааг тууштай ашиглаж чадахгүй байна.

Долоод, Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэлийн түвшинд хүрч, түүнчлэн БНХАУ-ын удирдлага Хятад-Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэж мэдэгдсэн¹ нь хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, ойрх ирээдүйн Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн хамгийн ойр орчинд таатай нөхцөл бүрдээд байгааг үгүйсгэж үл болно.

Наймд, Хонгконгийн ардчиллыг хумих БНХАУ-ын бодлого “нэг улс, хоёр систем” зарчмын мөн чанарыг алдагдуулж, энэ нь алсдаа Тайванийг эх газрын Хятадад нэгтгэх боломжийг үгүйсгэж байгаа болно.

Есд, Эрх мэдэл нэг хүний гарт улам бүр төвлөрч байгаа нь чинээлэг нийгмийг цоглоох, чинээлэг иргэдийн эрх чөлөөг эрхэмлэх үзэл бодолтой улам бүр зөрчилдөх болно.

Аравт, Урт, удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй Хятад, Америкийн сөргөлдөөн Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогод таатай нөлөө үзүүлэхгүй.

Арван нэгд, БНХАУ глобалчлал эргэлт буцалтгүй, бүх улс адил ашиг хүртэнэ гэдэг нь тийм ч үнэмшилтэй биш болов. Даяаршлын үйл явц улс орнуудын хөгжил, дэвшлийн өмнө өргөн боломж нээж байгаа нь үнэн боловч, жижиг бага, эмзэг эдийн засагтай улс орнуудын өмнө мөнхүү томоохон эрсдэл дагуулж байна. Дэлхийн эдийн засгийн шинэ тэнцвэрийг тогтоох шаардлагатай байна. Даяаршил, чөлөөт зах зээл, дижиталчлалын үйл явцыг зөв залж жолоодох буюу манипуляци хийх явдал зайлшгүй чухал болж байна. Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, хүртээмжтэй, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх явдал мөн.

Арван хоёрт, Чөлөөт худалдаа эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлнэ гэдэг ч бодит амьдралтай олон талаараа зөрчилдөж байсныг Умард Америкийн ЧХХ, Номхон далай дамнасан түншлэлийн хэлэлцээр харуулсан билээ. Үүнтэй нэгэн адил эдийн засгийн интеграц ч цорын ганц боломжит хувилбар биш гэдгийг ЕХ-ны интеграц харуулсаар байна.

1 Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С.Горбачева в Китайскую Народную Республику 15-18 мая 1989 года Документы и материалы. М., Изд. Политической Литературы. 1989, стр. 18

Арван гуравт, Даяаршил, чөлөөт зах зээл, дижиталчлалын үйл явцыг зөв залж жолоодох буюу манипуляци хийх явдал зайлшгүй чухал болж байна. Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, хүртээмжтэй, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх явдал мөн.

Арван дөрөвт, Монгол Улсын геополитикийн харьцангуй давуу талын хүчин зүйлийн ач холбогдол аажмаар буурах хандлага ажиглагдаж болзошгүйг тэмдэглэх хэрэгтэй. Хятадад кокс нийлүүлэх шинэ тоглогчид гарч ирэв. Хятадад кокс нийлүүлэх боломжтой цорын гагц улс нь Монгол биш гэдэг нь нэн тодорхой болов. Бид Австрали, Индонези, Канад зэрэг алс холоос өрсөлдөгч хайх шаардлагагүй. ОХУ-ын нүүрсний нөөц 193.3 тэрбум тонн, үүнээс 101.2 тонн нь хүрэн нүүрс, 85.3 тэрбум тонн, үүнээс 39.8 тэрбум тонн кокс, 6,8 тэрбум тонн антрацит буюу сайн чанарын чулуун нүүрс эзэлж байна.¹ Нөгөө талд дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор Хятад нүүрсний хэрэглээгээ эрс багасгах болж байгаа нь Монгол Улсын хувьд таатай биш. Мөн Хятадын эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ дэлхийн байгалийн баялаг, түүхий эдийг сорогч **black hole** байнга хэвээрээ байна гэсэн төсөөллөө өөрчлөх шаардлагатай болов уу.

Арван тавд, Хятадын удирдагч Ши Жиньпин УИХ-д үг хэлэхдээ чухал зүйлийг онцлон тэмдэглэсэн байна. Тэрбээр “Олон улсын нөхцөл байдалд ямарч өөрчлөлт гарсан хоёр улсын харилцааны гол чиг шугамаа дагаж, стратегийн түншлэлийн өнцгөөс нөгөө талынхаа эрх ашгийг бодолцож байх ёстой. Нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал зэрэг гол асуудал болон нөгөө талынхаа анхаарлаа хандуулж буй томоохон асуудалд тууштай, харилцан дэмжлэг үзүүлж байх хэрэгтэй” гэж хэлсэн нь анхаарал татсан асуудал юм. Тиймээс Монгол Улс ч өөрийн сүсэгтэн олон хийгээд дээрхийн гэгээн XIV Далай ламын хоорондын харилцааны асуудлыг хөндөж тавих боломжтой.

Арван зургаад, Хятадын эдийн засаг хурдацтай дижиталчлагдаж байна. Монгол Улс эл үйл явцтай хөл нийлүүлж дасан зохицох, хөрвөх, хариу барих чадавхтай байх шаардлагатай, дижитал дэд бүтцийг эрс сайжруулах ёстой.

Арван долоод, Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжил мэдэгдэхүйц удаашрах төлөв ажиглагдаж байгаа боловч үүнийгээ *өндөр хурдацтай хөгжлөөс өндөр чанарт суурилсан хөгжилд шилжисж байна гэж онцлон тэмдэглэж байгаа*² бөгөөд энэ нь глобал эдийн засгийн хөгжил, олон улсын харилцааны олон туйлт системийг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсээр байна.

Арван наймд, Монгол Улсын санаачилгаар эхэлсэн гурван хөршийн саммитын

1 Российский уголь. Росинфорумуголь. 2014. О Долгосрочной программе развития угольной промышленности России на период до 2030 года, 24 января 2012 г.

2 “The fourth plenary session of the 19th Central Committee of the Communist Party of China”-Xinhua. Oct. 28, 2019

агуулга нь цаашдаа зөвхөн хөрш хоёр гүрний худалдаа-эдийн засгийн бодлогод Монгол Улсыг хэрхэн яаж оролцуулах асуудлыг хэлэлцдэг механизм байж таарахгүй нь мэдээж төдийгүй, улам өргөн хүрээтэй асуудал хэлэлцдэг байх шаардлагатай нь харагдаж байна.

Арван есд, Монгол Улсын газар зүйн байршил, геополитикийн хүчин зүйлсийн хуучин статус мэдэгдэхүйцээр өөрчлөгдөж байна. Монгол Улс хоёр их гүрний дунд хавчуулагдсан, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алсалмагдал, хөгжлийн тусламж горилогч, буурай хөгжилтэй жижиг улс байсан бол эдүгээ аварга баавгай, аварга лууны дунд жороолж буй *pony* биш, харин ч *Asia's galloper* буюу *Азийн шандаст хүлэг* гэж хэлж болохоор, өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутаг, хамгийн том зах зээлийн дэргэд орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, хөрш болон бусад их гүрнүүд, үндэстэн дамнасан нийгэмлэгүүдийн геополитик, гео-эдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна.

Хорьд, Хятад, Америкийн хооронд өрнөж буй худалдааны дайн, технологи тэгээд визийн дайн болон өргөжиж буй нь Хятадын эдийн засгийн хөгжилд, цаашлаад Монгол Улсын эдийн засаг, мөнгөний ханш, инфляцид сөрөг нөлөөтэй.

Хорин нэгд, Монгол Улс АДБХОБ-ны анхны үүсгэн байгуулагч 21 орон мөний хувьд гурван улсын эрчим хүчний супер сүлжээ, төмөр замын коридор, хий дамжуулах мега төслийн хүрээнд хөгжлийн зээл авах чиглэлээр ажиллах шаардлага байна.

Хорин хоёрт, Хойд мөсөн далайн бүс нь байгалийн баялаг их нөөцтэй нь тодорхой болж, тиймээс ч холбогдох улс гүрнүүд дурдсан газар нутагт өөрийн туг далбаагаа хэдийн мандуулж эхэлжээ. Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтэй холбоотойгоор Хойд мөсөн далайгаар Хойд Европоос Зүүн Өмнөд Ази хүрэх усан замын урт 40 хувиар багасч, өртөг энэ хэмжээгээр буурах боломж өргөжиж,¹ “нэг бүс, нэг зам” санаачилга энэ чиглэлд анхаарлаа хэдийн хандуулж, БНХАУ, Энэтхэг, Сингапур улсууд хүртэл *Arctic Council*-д ажиглагч гишүүн орны статустай болсон нь Монгол Улс энэ чиглэлд үйл ажиллагаагаа идэвхжүүлж, ажиглагч гишүүнээр элсэх шаардлагатай болов уу.

Хорин гуравт, Олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үе шатанд Монгол Улс газар зүйн байршлын геостратегийн шинэ үнэлгээ өөрчлөлтийг урт, удаан хугацаанд хадгалах явдал чухал байна.

Эцэст нь, “Ковид-19” цар тахал, түүний үндэсний болон глобал эдийн засаг, геополитик, дэлхийн дэг журам, амьдралын хэв маягт маш хүчтэй нөлөөлж эхлэв. Гэхдээ энэ бол тэс өөр түүх ажгуу.

1 Is this a new era for the Arctic? <https://www.weforum.org/agenda/2019/11.27/is-this-a-new-era-for-the-arctic/>

Дүгнэлт

Монголчуудын нэг том дутагдал бол Хятадаас хамааралгүй хөгжчих гээд байдагт оршино. Мөн хоёр хөршөө гайхшируулсан үйл явдал бол хоёр хөрштэйгөө стратегийн түншлэлийн олон улсын эрх зүйн үндсийг баттай тавьсан атлаа байнга төвийг сахих санаачилга дэвшүүлж байсан явдал билээ. Түүнчлэн ШХАБ-д Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал хөндөгдөх тухайд ямагт хоёр хөршөө элдвээр муулж, тэд юу юуны түрүүгүй Монголыг өөрийн урхинд оруулж авах юм шигээр тайлбарлаж байгааг анхаарах асуудал мөн.

ОХУ, Монгол Улсын холбоотны харилцаа үгүй болж, шинээр иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон хэдий ч Монголын “буфер улс”-ын гүйцэтгэдэг геополитикийн үүрэг хэвээр, нөгөө талд ХХI зуунд Өмнөд хөршийн эдийн засгийн эрчимтэй хөгжил, батлан хамгаалах салбарын шинэчлэл нь сайхь улсыг геополитик, гео-эдийн засгийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэх боломж олгож байгааг Өрнөдийн судлаачид “*china threat*” хэмээн нэрлэдэг нь онход үндэслэлгүй зүйл биш болов уу. Үүнийг төрийн хар хайрцагны бодлого хэмээн авч үзэх ёстой болов уу.

Монгол Улсын гадаад бодлого, эдийн засгийн гадаад хамтын ажиллагааны механизм, түүний шийдвэр гаргах ажиллагааны шинжлэх ухаан, онол-арга зүйн үндсийг улам бүр төгөлдөршүүлэх шаардлага буй. Хөгжиж буй улсын үндэсний хөгжил дэвшил, аюулгүй байдлын баталгаажилтын чухал уг сурвалж нь үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, энхийг эрхэмлэсэн, идэвхтэй, олон тулгуурт, олон хэмжээст прагматик гадаад бодлого, дипломат ажиллагаа даруй мөн. Идэвхтэй гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах хүч мөн. Нөгөө нэг үгүйсгэж үл болох хүчин зүйл бол Хятадын эдийн засгийн хурдацтай хөгжлөөс үүдсэн түүхий эдийн эрэлт хэрэгцээ Монгол Улсад эерэг нөлөө үзүүлж буй явдал мөн.

Далайд гарцгүй Монгол Улсын туйлын сул талыг өөрийнх нь байгалийн баялаг, эрчимтэй хөгжиж буй Хятадын эдийн засгийн эрэлт хэрэгцээ, Орос, Хятадын иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл, Монголын геополитикийн орон зай, газар зүйн байршлын геостратегийн шинэ үнэлгээ харьцангуй давуу талыг буй болгож, эерэг тийш нь аажим боловч өөрчилсөөр буйг онцлон дурдах ёстой.

- Хоёр их гүрний дунд орших Монгол Улсын газар зүйн байршлын геостратегийн шинэ үнэлгээ өөрчлөгдөж байна. Үүнд: Монгол Улсын хойд хөрш дэлхийн хамгийн том нутаг дэвсгэртэй, цөмийн зэвсэгтэй, сэргэн мандаж буй, НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн ОХУ, Өмнөд хөрш дэлхийн хамгийн их хүн амтай, **өндөр хурдацтай хөгжлөөс илүү өндөр чанарт суурилсан хөгжилд шилжиж** буй¹, цөмийн зэвсэгтэй, НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн БНХАУ, ийм онцлог хоёр хөршөөр хүлээлэгдсэн цорын ганц гэж хэлж болохоор, Европарламентын тогтоолд тэмдэглэсэнээр

1 “The fourth plenary session of the 19th Central Committee of the Communist Party of China”-Xinhua. Oct. 28, 2019

“геополитикийн давтагдашгүй байршилтай”.¹


- Өрнөдийн эдийн засгийн хоригтой холбоотойгоор ОХУ-ын Алс Дорнодын бодлого, ялангуяа БНХАУ-ыг чиглэсэн бодлого идэвхэжсэн нь Монгол Улсын геополитикийн ач холбогдлыг мэдэгдэхүйц өсгөв.
- Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэлийн (*comprehensive strategic interaction partnership*) түвшинд хүрсэн нь Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин сайн байна гэж үзэж болох талтай. 2018 онд Орос, Хятадын худалдааны эргэлт 30 хувийн өсөлт үзүүлж, анх удаа 100 тэрбум ам.долларын босгыг давж, 107.06 тэрбум ам.долларт хүрснийг Хятадын Худалдааны яамны хэвлэлийн төлөөлөгч Гао Фен (Gao Feng) болон Гаалийн Ерөнхий газар албан ёсоор зарлав.² Энэ үзүүлэлтийг хоёр хөрш 2023 гэхэд 200 тэрбум ам.долларт хүргэхээр тохиролцсон нь Монгол Улсын газрын гүүр, идэвхтэй транзит орон болох зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Монгол Улс бүс нутагтаа хөрш гүрнүүдтэйгээ улс төр, газар нутгийн аливаа маргаангүй, түншлэлийн эрх зүйн үндсийг баттай тавьсан бөгөөд Монгол Улс 2002 онд ОХУ-тай 3543 км урт хилийг хамтран шалгаж эцэслэн тодотгосон бол, 2001-2004 онд БНХАУ-тай хилээ хоёр дахь удаагаа хамтран шалгаж, 4676.8 км урт хилийн шугамыг тогтоож, Монгол Улсын хилийн багануудыг анх удаа боржин чулуугаар шинэчлэн босгож, НҮБ-д бүртгүүлэв. Ийнхүү өнөөдөр Монгол Улсын хилийг эмжсэн 8219 км 895 м урт хил олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байна.
- Монгол Улс Орос-Хятадыг дөт замаар, Зүүн Ази, Солонгосын хойг-ЕХ-г холбох *landbridge* хийгээд *transit* улс болох боломж байна.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогоо хэрэгжүүлэх гадаад орчин 1990-ээд оноос үндсээрээ өөрчлөгдсөн гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс төлөвшиж буй олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцооны татах хүчний яг төвд нь оршиж байна. ОХУ, БНХАУ-ын оройлолтой олон туйл дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад ШХАБ, БРИКС, ЕАЭЗХ, АДБХОБ, “Нэг бүс ба нэг зам” санаачилга чухал үүрэг гүйцэтгэж байна.

1 The European Union is intent on supporting Mongolia in its continued political and economic reform path, as a valuable partner for the EU in Asia. Factsheet on the EU-Mongolia Framework Agreement on Partnership and Cooperation. Bruxelles, 17/02/2017

2 *Ibid.*, Russia’s trade with China surges to more than \$107 billion .RT 14 Jan, 2019
<https://www.rt.com/business/448783-russia-china-trade-turnover/>
China-Russia trade volume tops 100 bln USD, Xinhua. 2019.01.10
http://www.xinhuanet.com/english/2019-01/10/c_137734116.htm



ОХУ, БНХАУ-аар оройлсон олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах, гурвалсан хөршийн бодлого, “гуравдагч хөрш”-ийн бодлогын хооронд стратегийн тэнцвэрийн хүчийг олох (хүчний тэнцвэр барих биш Д.У онцлов), эрх ашгийн тэнцвэрийг зөв барих явдал тулгамдсан чухал асуудал болж байна.

Эцэст нь, 2020 онд Хятадаас “гаралтай” байж болзошгүй шинэ коронавирусын цар тахал, түүний дэлхийн нийт улс орнуудад үзүүлж буй гамшигийн нөлөө, COVID-19 цар тахлын дараах дэлхийн дэг журмын дүр төрийн тухайд төсөөлөл бол энэ нь тэс өөр түүх болно.